



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх, акталж,  
данснаас хасах зөвшөөрөл  
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2, 6.2.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймгийн Шарын гол сумын цэвэр усны эх үүсвэрийн шугам хоолой, гүний худаг болон барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон нийт 365,256,005.00 (гурван зуун жаран таван сая хоёр зуун тавин зургаан мянга таван) төгрөгийн балансын үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан хөрөнгийг “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 315,016,791.17 (гурван зуун арван таван сая арван зургаан мянга долоон зуун ерэн нэгэн төгрөг арван долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

3. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Эхнцэцэгт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх, акталж, данснаас хасах, устгах ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн  
 39... дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



"Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн  
 дансанд бүртгэх барилга байгууламж

Д/д	Барилга байгууламжийн нэр, байршил	Хөрөнгийн нэр	Барилга		Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дугаар	Улсын комиссын акт дугаар	Төсөвт өртөг (төгрөг)
			Эхэлсэн	Дууссан					
<i>Цахилгаан дамжуулах сүлжээ, дэд станц</i>									
1	Дархан-Уул аймгийн Шарын голын цэвэр усны эх үүсвэрийн шугам хоолой, гүний худаг болон барилга байгууламж	Цэвэр усны хос шугам	2010	2010	ЗТБХБЯам	"ЧММ" ХХК	БЗА-2010/06/44	2010-07-21 01/13-2010	365,256,005.00
	<b>Нийт дүн</b>								365,256,005.00 (гурван зуун жаран таван сая хоёр зуун тавин зургаан мянга таван)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 02-дугаар сарын 29-ны өдрийн  
 39-дугаар тогтоолын 2-дугаар хавсралт



"Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн  
 үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэм жих нэгж	Тоо	Ашиглал тад орсон он	Бүгд		Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл үнэ /төгрөг/
					Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/		
1	Дулааны шугам хоолой	м	6720	1984	16,256.16	109,241,365.17	109,241,365.17	0
2	Цэвэр усны шугам	м	3634	1980	56,625.05	205,775,426.00	205,775,426.00	0
	Нийт дүн		10354		72,881.20 (далан хоёр мянга найман зуун наян нэгэн төгрөг хорин мөнгө)	315,016,791.17 (гурван зуун арван таван сая арван зургаан мянга долоон зуун ерэн нэгэн төгрөг арван долоон мөнгө)	315,016,791.17 (гурван зуун арван таван сая арван зургаан мянга долоон зуун ерэн нэгэн төгрөг арван долоон мөнгө)	